




ХАЛДЛАГАД ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ БАГ

НЭГ. ЦАХИМ ХУУДАСНЫ СЕРВЕРТ НӨӨЦЛӨЛТ ХИЙХ**1.1. Цахим хуудасны бүх файлыг архивлах:**

- Байгууллагын “cpanel” эрхээр нэвтэрнэ.
- “File manager” рүү орно.
- “Public_html” хавтсыг сонгож “compress” хийнэ.
- **Архив хийсэн файлыг нөөцлөлт хийж устгах!!!**

Уг архив файлыг устгахгүй орхих нь системийн нөөцийг багасгахаас гадна тус файлд таны серверийн эх код, өгөгдлийн сангийн хандалтын эрх нэвтрэх нэр, нууц үг байдаг тул халдагч этгээдэд алдах эрсдэлтэй.




Зураг-1 Cpanel нөөцлөлт хийх заавар

1.2. Өгөгдлийн сан нөөцлөлт хийх тухай:

- Байгууллагын “cpanel” эрхээр нэвтрэх.

- “phpMyAdmin” рүү орох.
- Өгөгдлийн сангаа сонгож дарах.
- Export цэс рүү орж Go товчийг дарах.



Зураг-2 Өгөгдлийн сан нөөцлөх

Та өөрийн цахим хуудасны серверийн нөөцлөлтийг тогтмол хийж сурснаар системийн хэвийн найдвартай байдлыг хангана. Цахим хуудасны серверийг нөөцлөлт хийснээр доорх эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой. Үүнд:

- Халдлагад өртөхөд хуучин хувилбар руу буцаах
- Хөгжүүлэлтийн явцад гарсан алдааг хуучин хувилбар руу буцаах
- Санаатай болон санамсаргүй байдлаар устгагдсан файлыг сэргээх

ХОЁР. ЦАХИМ ХУУДАСНЫ СИСТЕМИЙН ХУВИЛБАР ШИНЭЧЛЭХ ТУХАЙ

2.1. Drupal 7 & 8 хувилбар шинэчлэх:

- Цахим хуудасны серверийг нөөцлөх.
- Цахим хуудсыг “maintenance” горим руу шилжүүлэх.
- “sites” хавтаснаас бусад бүх файл, хавтсыг устгах.
- “.htaccess”, “robots.txt” файлуудыг устгах.
- “sites” хавтаснаас бусад шинэ бүх файлуудыг “upload” хийх.
- “.htaccess”, “robots.txt” файлуудыг шинээр “upload” хийх.
- “yourdomain.mn/update.php” дуудаж ажиллуулах.
- “maintenance” горимыг буцаах.
- Цахим хуудсыг ажиллуулах.

Гарын авлагын дэлгэрэнгүй линк: <https://www.drupal.org/node/1223018>

2.2. Joomla 3.* хувилбар шинэчлэх:

- Цахим хуудасны серверийг нөөцлөх.
- “Component → Joomla Update” “update url” дарж хувилбар шинэчлэх пакетыг татаж авна.
- Хувилбар шинэчлэх пакетыг /tmp хавтас руу хуулна.
- “Component → Joomla Update” руу орж хувилбарыг шинэчлэх.

Гарын авлагын дэлгэрэнгүй линк:

https://docs.joomla.org/J3.x:Upgrading_from_Joomla

2.3. Wordpress хувилбар шинэчлэх:

Хувилбар шинэчлэхэд автомат болон гар аргаар хийж болно. Та wordpress үндсэн файлд өөрчлөлт хийсэн бол устахыг анхаарна уу.

Автомат арга:

- Цахим хуудасны серверийг нөөцлөх.
- Dashboard → update → install now даргах.

Гар арга:

- Цахим хуудасны серверийг нөөцлөх
- Wordpress сүүлийн хувилбар татаж авах
- Цахим хуудасны бүх “plugin”-г deactivate хийх
- ftp эрхээр нэвтэрч wp-admin, wp-includes хавтсыг устгах
- Татаж авсан пакетаас wp-admin, wp-includes хавтсыг хуулах
- Татаж авсан пакетаас wp-content хавтас дотор байгаа файлуудыг дарж хуулах.
- Татаж авсан пакетаас үндсэн хавтсанд байгаа сул файлуудыг дарж хуулах.
- Админ эрхээр нэвтрэх
- <http://yourdomain.mn/wp-admin/upgrade.php>
- Цахим хуудасны бүх “plugin”-г reactivate хийх

Гарын авлагын дэлгэрэнгүй линк:

https://codex.wordpress.org/Updating_WordPress

ГУРАВ. ЦАХИМ ХУУДАСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ

Цахим хуудасны системийн аюулгүй байдлын сайжруулах үүднээс доорх тохиргооны дагуу тохируулга, саналыг .

- Системийн нууц үгийг сард нэг удаа солих.
- Нууц үгийн урт 13-с дээш том, жижиг үсэг, тоо, тусгай тэмдэгт орсон байх.
- Файл, хавтасны хандах эрхийг “777” тохируулахгүй байх.
- Файлын хандах эрхийг хамгийн ихдээ “644” тохируулах
- Хавтасны хандах эрхийг хамгийн ихдээ “755” тохируулах
- Гуравдагч этгээдийн хөгжүүлсэн “component, plugin” аль болох бага хэрэглэх, онцын шаардлагагүй тохиолдолд хэрэглэхгүй байх.
- Кракдсан “theme” хэрэглэхгүй байх.
- Албан ёсны “theme” ашиглах эсвэл өөрсдөө хөгжүүлж хийх.
- Нэмэлтээр “plugin” хийх, “theme” хөгжүүлэх гэж байгаа бол аюулгүй байдлыг сайтар хангах.